



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 57,190,062.18 (тавин долоон сая нэг зуун ерэн мянга жаран хоёр төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 20,000,000.00 (хорин сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Жижиг, дунд үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132001694

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт



**"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл/ төгрөг/	Цаашид ашиглах жил /тоогоор/		Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/
					/төгрөг/		
1	Суудлын автомашин TOYOTO LAND CRUISER 200 JTMCU09JX05034852, улсын дугаар 12-77 УНА	2010/2010	368607	57,190,062.18		6	20,000,000.00
				57,190,062.18			20,000,000.00
	НИЙТ ҮНЭ			(тавин долоон сая нэг зуун ерэн мянга жаран хоёр төгрөг арван найман мөнгө)			(хорин сая)